



ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭВСЭЛ намын Сенатын  
2024 оны 03 дугаар сарын 24-ний  
Өдрийн N°02 тогтоолын хавсралт N°01



**ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭВСЭЛ нам**

**МӨРИЙН ХӨТӨЛБӨР- 2024**

“Хувь хүний эрх чөлөө - Хязгаарлагдмал төр”



## **ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Монгол улсын үндсэн хууль, Эрх Чөлөөний Эвсэл намын Баруун жигүүрийн үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомжуудыг үндэслэл болгон мөрийн хөтөлбөрөө боловсруулав.

### **1. ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦООГ ХЯЗГААРЛАХ**

#### **2. ХЯЗГААРЛАГДМАЛ ТӨР**

#### **3. ЭРЧИМ ХҮЧ, ДЭД БҮТЭЦ**

#### **4. ГАДААД ХАРИЛЦАА**

#### **5. БОЛОВСРОЛ**

#### **6. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ**

### **1. ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦООГ ХЯЗГААРЛАХ**

1. Эх үүсвэргүй, үрэлгэн төсөвт “Алсын хараа – 2050” баримт бичгийг хүчингүй болгоно
2. Монгол улсын төв банкыг татан буулгана
3. Төрийн өмчийн оролцоотой банкуудыг татан буулгана
4. Засгийн газрын тусгай сангуудыг бүхэлд нь татан буулгана
5. Зээлийн хүүг хязгаарласан аливаа хууль журмыг хүчингүй болгоно
6. Төсвөөс санхүүжүүлдэг халамжийн хэмжээг 60% бууруулна
7. Татварын хэмжээг 60% бууруулна
8. Импортын татварыг 50% бууруулна
9. Төрийн өмчит компаниудыг бүхэлд нь хувьчилна (МИАТ, улсын үйлдвэрүүд)
10. Оюутолгой, Эрдэнэт зэрэг мега төслүүдийн төрийн хувь эзэмшлийг бууруулна
11. Шатахуун импортын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь цуцална
12. Эрчим хүчний үнийг чөлөөлж, эрчим хүчний төслүүдийг төрийн хамаарлаас чөлөөлнө
13. Мал аж ахуй, махны экспортыг чөлөөлнө
14. Бизнес, эрхлэгч ААН-ийн тусгай зөвшөөрөл авах хууль журмыг хүчингүй болгоно
15. Үйлчилгээ, бизнесийн аливаа цагийн хуваарийн хязгаарлалтыг хүчингүй болгоно
16. Төр хувийн өмчид халдахыг хуулиар хязгаарлана
17. Эдийн засгийн эрх чөлөөг бий болгож, хувийн өмчийг хамгаална

### **2. ХЯЗГААРЛАГДМАЛ ТӨР**

18. Төсвийн зардлыг 60% бууруулна
19. Засгийн газрын цомхотгож, яамдуудын тоог 9-с дээшгүй байхаар хязгаарлаж, дэд сайд болон бусад данхар бүтцийг цомхотгоно
20. Төрийн албан хаагчдын тоог 60% цомхотгоно
21. Авилгатай тэмцэх газрыг татан буулгана
22. МҮОНРТ-г татан буулгана
23. Цагдаа, прокурорыг татан буулгах замаар форматлаж, шинэчлэн зохион байгуулна
24. Дотоодын цэргийг татан буулгана
25. Монгол улсын арми, нисэх хүчнийг шинээр байгуулж, цэргийн номлолыг бүхэлд нь өөрчилнө. Армид алба хаах хугацааг 4 сар болгож, барууны стандарт бүхий хөтөлбөр хэрэгжүүлж, зэвсэг техникийн шинэчлэл хийнэ
26. Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааг шинэчлэн, барууны стандарт бүхий техник, сургалтын хөтөлбөртэй болгоно
27. Төр, хувийн хэвшлийн түншлэл гэх завхарлыг хална
28. Хэвлэл мэдээллийн байгууллагаас төр худалдан авалт хийхийг хориглоно
29. Бүх түвшинд төсвийн хөрөнгөөр гадаад, дотоодын аливаа ажлын айлчлал, аялалыг 80% бууруулна
30. Төсөвт зардал бүхий хурал хэлэлцүүлэг зөвлөгөөний санхүүжилтийг бүхэлд нь хязгаарлана
31. Төр аливаа хэлбэрээр үнэ тогтоох, зах зээлд мөнгө нийлүүлэх, интервенц хийхийг хуулиар хязгаарлана



### **3. ЭРЧИМ ХҮЧ, ДЭД БҮТЭЦ**

32. Хийн хоолойн гэрээг цуцалж, хүчингүй болгоно
33. Босоо, хэвтээ чиглэлд ОУ-н стандарт бүхий нарийн царигийн шинэ төмөр замын сүлжээ барих төслийг хэрэгжүүлэх гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад шаардагдах хууль эрх зүйн орчин, боломжуудыг нээлттэй болгоно
34. Нийслэл, Баруун аймгийг шууд чиглэлээр холбосон хурдны галт тэрэг, хурдны зам барих төслийг хэрэгжүүлэх гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад шаардагдах хууль эрх зүйн орчин, боломжуудыг нээлттэй болгоно
35. Хувийн хурдны зам барьж байгуулах эрхийг нээлттэй болгоно
36. Атомын цахилгаан станц байгуулахтай холбоотой тодорхойгүй нөхцөл байдлыг шийдвэрлэж, тодорхой хууль тогтоомжоор хэрэгжилтийг хамгаална
37. Эрчим хүчний хараат байдлаас гарах аливаа төслүүдэд саад бэрхшээл учруулах нөхцөл байдлыг шийдвэрлэж, тодорхой хууль тогтоомжоор хэрэгжилтийг хамгаална
38. Уул уурхайн хайгуулыг 50% нэмэгдүүлнэ
39. Нүүрсний цахилгаан станцуудыг 100% нэмэгдүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бий болгож, хязгаарлалтуудыг чөлөөлнө
40. Байгалийн хийн хайгуул, олборлолтын хөрөнгө оруулалтыг хамгаалж, хязгаарлалтуудыг чөлөөлж, компаниудыг тодорхой хууль тогтоомжоор хэрэгжилтийг хамгаална
41. Нийтийн тээврийг өрсөлдөөнийг чөлөөлнө

### **4. ГАДААД ХАРИЛЦАА**

42. Гуравдагч хөршийн бодлогыг шинэ түвшинд гаргана
43. Хоёр хөрштэй харилцах харилцаанд дүгнэлт хийж, үзэл баримтлалаа шинээр тодорхойлно
44. Монгол улсаас гадаад улсад суух элч төлөөлөгчийн үйл ажиллагаа, бодлогыг шинэчилнэ
45. Гадаад паспортоор визгүй зорчих улсын тоог 100 хүртэл нэмэгдүүлнэ
46. Нийслэл хотод байрлаж буй элчин сайдын яамдуудыг нүүлгэн шилжүүлж, элчингийн төвлөрсөн хороолол байгуулж, ажиллах нөхцөл, аюулгүй байдлыг сайжруулна. Гуравдагч хөрш орнуудын байнга суух элчин, консулын газруудыг нэмэгдүүлэх нөхцөл боломжийг сайжруулна
47. ОХУ-тай визний нөхцлийг сэргээнэ

### **5. БОЛОВСРОЛ**

48. Боловсролын хөтөлбөрийг бүхэлд нь шинэчлэнэ
49. Кирилл үсгийг халж латин үсэгт шилжинэ (Монгол бичиг, Латин хосолсон)
50. Соёлын яамыг татан буулгаж, төсвөөс санхүүждэг аливаа дуу бүжгийн чуулгууд болон соёл урлагийн гэх салбарын санхүүжилтийг зогсооно
51. Түүх бичлэгийг шинээр эргэн харна
52. Түрэмгийлэгч улсын үзэл суртлын төвүүд, хөшөө барималыг татан буулгана

### **6. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ**

53. Хууль тогтоомжуудыг бүхэлд нь шинэчлэн найруулна
54. Хууль дагасан журмуудыг хүчингүй болгоно
55. Улс төрийн намыг төрөөс санхүүжүүлэх хуулийг хүчингүй болгоно
56. Улс төрийн намд иргэн, ААН-ийн өгөх хандивын дээд хязгаарыг нэмэгдүүлнэ
57. Намын хатуу гишүүнчлэлийг хална
58. Улс төрийн нам үүсгэн байгуулах босго шаардлагыг хүчингүй болгоно
59. МАН-ыг татан буулгаж, бүх улс төрийн намуудыг шинэчлэн бүртгэнэ
60. Эрүүл мэндийн салбар дахь төрийн оролцоо, хоцрогдлыг халж, шинэчлэл, чөлөөт өрсөлдөөн бий болгоно
61. Эрүүл мэндийн боловсролыг боловсролын хөтөлбөрт оруулна
62. Сонгуулийн ерөнхий хороог татан буулгаж, Сонгуулийн төв байгууллагыг шинэчлэн зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжуудыг шинэчилнэ
63. Үндэсний аудитын газрыг татан буулгаж, Төрийн аудитын тухай хуулийг хүчингүй болгож, хараат бус Аудитын цомхон бүтцийг шинэчлэн байгуулна